



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/350

Хэрлэн сум

Монгол Улсын Ерөнхийлөгчийг хүлээж авах
бэлтгэл ажилд зориулж, хөрөнгө
зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийг хүлээж авах бэлтгэл ажлын хүрээнд Ерөнхийлөгчийн Тамгын газрын Төрийн ёслол хүндэтгэл, хамгаалалтын албаны ажилтнууд болон Үндэсний урлагийн их театрын уран бүтээлчдийг Хэнтий аймагт ажилласантай холбогдуулан 9,878,000 (есэн сая найман зуун далан найман мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.НОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2022 оны
06 дугаар сарын 28-ны
А/350 захирамжийн хавсралт

Шаардагдах зардлын тооцоо

№	Зардлын нэр	Тоо	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Хоол	20 хүн	15.000*4	1.200.000
2	Буудал	10 өрөө	90.000*2	1.800.000
3	Урлагийн тоглолтод оролцогчдийн байр, хоол	76 хүн	45.300*2	6.878.000
Дүн				9.878.000

Хоршооны хөгжлийг дэмжих жилийн хүрээнд